



МОНГОЛ УЛС  
МОНГОЛБАНК

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 3, Утас: 31-03-92, Факс: (976-11) 31-14-71,  
<http://www.mongolbank.mn>

2017.12.11 № А-1/1311

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА Ц.ЦОЛМОН ТАНАА

Улсын Их Хурлын гишүүн Т.Аюурсайханаас  
Монголбанкинд хандаж тавьсан асуулгын хариултыг  
УИХ-аар сонсох гэж байгаатай холбогдуулан шинэчлэн  
хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт : 3 хуудастай.

Хүндэтгэсэн

МОНГОЛБАНКНЫ  
ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.БАЯРТСАЙХАН

Т 4 - 4553

A5-2017.doc

Монголбанкны 2017 оны  
12 дугаар сарын 11-ны өдрийн  
А-1/131 тоот албан бичгийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Т.АЮУРСАЙХАНААС ТАВЬСАН АСУУЛГАД  
ӨГӨХ ХАРИУЛТ

Манай улсын хэрэглээний сагсны 40 хувь нь цэвэр импортын бараа, бүтээгдэхүүн байгаагийн дээр дотоодод үйлдвэрлэгддэг бүтээгдэхүүний орцыг импортоор авдаг. Нийт зээлийн 20 гаруй хувь нь гадаад валютын зээл байна. Түүнчлэн манай улс жилд дунджаар гадаад өрийн хүүний төлбөрт 800 сая ам.доллар, үндсэн төлбөрт 1.7 тэрбум ам.доллартай тэнцэх хэмжээний төлбөр төлж байна. Иймд төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн өөрчлөлт нь инфляцид нөлөөлөхийн зэрэгцээ чанаргүй зээл, дотоодын аж ахуйн нэгжүүдийн гадаад өрийн дарамтад нөлөөлдөг. Иймд Монголбанк макро эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдлыг хангах чиг үүргийн хүрээнд валютын ханшийн тогтвортой байдалд анхаарч ирсэн. Тухайлбал, макро эдийн засгийн суурь нөхцөл (төлбөрийн тэнцэл, төсвийн алдагдал, гадаад валютын нөөц зэрэг)-тэй нийцгүй ханшийн огцом хэлбэлзэл үүссэн нөхцөлд хэлбэлзлийг бууруулах арга хэмжээний хүрээнд валютын захад шаардлагатай тухай бүр нь зохих түвшинд оролцож ирсэн.

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш 2016 оны 6 дугаар сараас огцом сулрахад дараах үндсэн 3 хүчин зүйлс нөлөөлсөн: (1) 2016 оны эхний хагаст Засгийн газраас хэрэгжүүлсэн “сайн” хөтөлбөрүүдийг Төв банкны оролцоотой санхүүжүүлсэн нь эдийн засаг дах төгрөгийн нийлүүлэлтийг нэмэгдүүлж, төгрөгийн ханш сулрах суурь шалтгааныг бүрдүүлсэн. (2) 2016 оны 6 дугаар сарын сүүлээр Эрдэнэт үйлдвэрийн 49 хувийг үндэсний компани худалдан авах үед дотоодын банкны салбараас их хэмжээ (нийт дүнгээр тухайн үеийн гадаад валютын нөөцийн 30 хувьтай тэнцэх)-ний валют гадаад төлбөрт шилжсэн нь валютын зах зээлд том цочрол бий болгосон. (3) Өмнөх жилүүдэд засгийн газар, хөгжлийн банкны хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд эдийн засаг дахь төгрөгийн нийлүүлэлт их хэмжээгээр нэмэгдэж, үүнээс үүдэн төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн сулрах дарамт нэмэгдэх бүрийд валютын зах дээр интервенци хийж ирсэн. Үүний үр дагаварт гадаад валютын нөөц бага түвшинд хүрч буураад байсан тул энэ том хэмжээний шоконд Монголбанк валютын интервенц хийх замаар хариу арга хэмжээ авах нь ханшийн хямралд хүргэх маш том эрсдэлтэй байв. Нэгтгэн хэлбэл, төгрөгийн их хэмжээний нийлүүлэлт хийгдсэн үед дотоод эдийн засгаас их хэмжээний валют бөөн дүнгээр гадагшилсан нь төгрөгийн ханш богино хугацаанд хүчтэй сулрахад нөлөөлсөн. Энэ үед төв банкны валютын нөөц цэвэр дүнгээр сөрөг өндөр түвшинд хүрсэн байсан тул валютын захад үргэлжлүүлэн их хэмжээний интервенци хийх боломжгүй буюу хямралд хөтлөх эрсдэлтэй байв. Энэхүү сулралт эрчимжихэд банкууд зарах валютын хэмжээндээ хязгаар тогтоож, валют худалдан авахын төлөөх түр зуурын сандрал бий болсон нь нөлөөлсөн.

Энэ үед төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг хангах, төгрөгөөс гадаад валют руу зугтах үзэгдлийг зогсоох, төгрөгийн активын өгөөжийг нэмэгдүүлэх, үндэсний мөнгөн тэмдэгтийн, санхүүгийн салбарын, төлбөрийн тэнцлийн хямралаас сэргийлэх зайлшгүй шаардлагыг харгалзан Монголбанкны Захирлуудын зөвлөлийн 2016 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн хурлын шийдвэрээр бодлогын хүүг 4.5 нэгж хувиар нэмэгдүүлсэн.

Үүний үр дүнд төгрөгийн ханшийн эрчимтэй уналтыг зогсоож, санхүүгийн салбарт тогтворгүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлсэн. Харин гадаад валютын зах зээлд тогтворжилт ажиглагдаж эхлэхэд бодит эдийн засгийг дэмжих шаардлагыг харгалзан бодлогын хүүг шат дараатай 2 удаа буулгаснаар одоо бодлогын хүү 12 хувьтай байна. Инфляци, эдийн засгийн идэвхжил, ханшийн цаашдын төлөв нь бодлогын хүүг үргэлжлүүлэн бууруулах эсэх шийдвэрт нөлөөлнө. Бодлогын хүүний одоогийн түвшин нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад тулгуурласан түвшин гэж Монголбанк үзэж байна.

Бусад макро суурь хүчин зүйлс, иргэдийн эдийн засгийн цаашдын төлөвийн талаарх хүлээлт зэрэг нь ханшийг сулрах чиглэлд нөлөөлж байхад бодлогын хүүний 4.5 нэгж хувийн өсөлт нь төгрөгийн ханшийг тогтворжуулахад чухал үүрэг гүйцэтгэсэн боловч, сулралтыг бүрэн зогсооход хүч мөхөстсөн. Тухайлбал, төсвийн алдагдал ДНБ-ий 16 хувьд хүрч, валютын орох урсгал зогсонги байдалд орж, иргэд гадаад валютын нөөц, гадаад өрийн талаарх бодит мэдээллийг авч эдийн засгийн цаашдын төлөвийн талаарх хүлээлтээ өөрчилснөөр төгрөгийн ам.доллартай харьцах ханш суларсан. Зээлжих зэрэглэл тогтоогч байгууллагууд манай улсын зэрэглэлийг богино давтамжтай бууруулж, гадаад хөрөнгө оруулагчдын манай эдийн засагт итгэх итгэл суларч, гадаад валютын нөөц бага түвшинд хүрч, валютын орох урсгал татарч, том дүнтэй гадаад төлбөрүүд хүлээгдэж буй орчинд валютын ханш сулрах нь гарцаагүй байсныг энд дурдах нь зүйтэй. Энэ орчинд ханшийг тогтвортой байлгах гэж оролдох нь эдийн засгийг илүү том хямралд хүргэдгийг дэлхийн олон хямралын түүх сануулдаг.

Эдийн засгийн энэ хүнд орчинд Засгийн газар, Монголбанк эдийн засгийн нөхцөл байдлын үнэлгээг шуурхай хийж, бодлогын шийдвэрийг зоригтой гаргасан. Энэ нь эдийн засагт үүссэн нөхцөл байдал, хүлээгдэж буй том дүнтэй гадаад төлбөрүүдийг Монгол улс дан ганц өөрийн санхүүгийн боломжоор даван туулж чадахгүй, харин олон улсын банк, санхүүгийн байгууллагууд, бусад улс орнуудын тусламжийг авах явдал юм. Энэ хүрээнд Олон улсын валютын сан (ОУВС)-гийн дэмжлэгтэйгээр донор байгууллага, улс орнуудаас санхүүгийн дэмжлэг авахаар 2016 оны 9 дүгээр сард ОУВС-гийн хөтөлбөр авч хэрэгжүүлэх хүсэлт хүргүүлсэн. Энэ хүсэлтийн дагуу ОУВС-гийн хөтөлбөрийг ажлын хэсгийн түвшинд 2017 оны 2 дугаар сард тохирч, 5 дугаар сарын 24-нд албан ёсоор ОУВС-гийн захирлуудын зөвлөлөөр хөтөлбөрийг батлуулсан. Хөтөлбөрийг ажлын хэсгийн түвшинд тохирсноор Чингис бондын 500 сая ам.долларын төлбөрийг Засгийн газрын бондоор амжилттай сольж, дотоод эдийн засагт нааштай өөрчлөлтүүд гарч эхэлсэн. Тухайлбал, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш тогтворжиж, гадаадын хөрөнгө оруулагчид, бизнес эрхлэгчдийн бодлогын талаарх тодорхой бус байдал арилж, итгэл сэргэж эхэлсэн. Энэ нөхцөл байдал нүүрсний экспортын өсөлттэй ижил цаг хугацаанд давхацсанаар эдийн засгийн идэвхжил ч сэргэж, 2017 оны эхний 3 улирлын байдлаар эдийн засгийн өсөлт 5.8 хувьтай байна. Иргэд, аж ахуйн нэгжүүдийн төгрөгийн ханшийн талаарх хүлээлт тогтворжиж, Монголбанк ч гадаад валютын нөөцөө нэмэгдүүллээ. 2017 оны 12 дугаар сарын эхний байдлаар Монголбанкны гадаад валютын нөөц 2.3 тэрбум ам.доллар байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс бараг 2 дахин өссөн үзүүлэлт юм.

Таны асуулгад дурдагдсан валютын ханшийн өсөлтийг таслан зогсоох, цаашид бууруулах, төгрөгийн худалдан авах чадварыг нэмэгдүүлэх арга хэмжээний тодорхой саналыг судлан үзээд дор дурдсан тайлбарыг хүргүүлж байна. Үүнд:

1. *“Гадаад валютын орлого олдгоос бусад аж ахуй эрхлэгч, иргэд банк болон банк бус санхүүгийн байгууллагад гадаад валютын хадгаламжтай байхыг хориглох”*

Валютын хадгаламжийн эдийн засагт үзүүлж буй нөлөөний талаар тантай санал нэг байна. Валютын зохицуулалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 9-д зааснаар байнга болон түр оршин суугч нь Монголбанкнаас гадаад төлбөр, тооцооны эрх олгосон арилжааны банк болон тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын банкны салбарт гадаад валютын данстай байж болно гэсэн хуулийн зохицуулалт үйлчилж байна. Иймд Монголбанкны зүгээс валютын хадгаламжийг шууд хориглохоос өмнө зах зээлийн механизмаар дамжуулан хадгаламжийн долларжилтыг бууруулах арга хэмжээ авахаар ажиллаж байна.

Захиргаадалтын аргаар хориглох нь эдийн засаг, санхүүгийн зах зээл дээр сөрөг нөлөө үзүүлж болзошгүй гэж болгоомжилж байна. 2017 оны 10 дугаар сарын байдлаар гадаад валютын хадгаламжийн хэмжээ 1 тэрбум ам.доллар, харилцахын хэмжээ 700 сая ам.доллар байна. Ханш үргэлжлэн суларна гэсэн хүлээлттэй орчинд энэ төрлийн хориглох шийдвэр гарснаар бүх харилцах, хадгаламж нь төгрөг рүү шилжихээс илүүтэй гадаад улс руу шилжинэ. Хэрэв хөрөнгийн зугталт бий болвол ханшийн сулралтыг улам эржимжүүлэхийн дээр санхүүгийн салбарын тогтворгүй байдлыг бий болгоно. Иргэд, ААНБ болон Засгийн газрын түвшиндээ ч бараг хуримтлал хийдэггүй манай улсын хувьд гадаад валютын хадгаламжтай байхыг хориглох нь хөрөнгийн зугталтыг бий болгож, эдийн засгийн өсөлтийг хангахад шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг багасгах нөлөөг үзүүлэх эрсдэлтэй юм. Иймээс эерэг нөлөөнөөсөө сөрөг нөлөө нь давамгайлдаг аливаа төрлийн захиргаадалтын зохицуулалтаас татгалзаж, зах зээлийн механизмд нийцсэн, макро зохистой бодлогын арга хэрэгслүүдийг 2018 оноос шат дараатай авч хэрэгжүүлэхээр Монголбанк төлөвлөж байна. Эдгээр арга хэмжээний үр дүнд банкны хувьд гадаад валютын хадгаламж татан төвлөрүүлэх нь илүү зардалтай болж, төгрөгийн үйл ажиллагаанд нь дарамт нэмэгдэх механизмд суурилан хадгаламжийн долларжилтыг бууруулах хөшүүрэг болно.

2. *“Банк бус санхүүгийн байгууллага гадаад валютын зээл олгодог явдлыг таслан зогсоох”.*

Таны ирүүлсэн (2) – (4) дүгээр саналд агуулагдаж буй ханшийн эрсдэлтэй валютын зээлийн эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөний талаар санал нэг байна. Ийм ч учраас Монголбанк ханшийн эрсдэлтэй зээлийн долларжилтыг бууруулах бодлогын арга хэмжээ авахаар ажиллаж байна

Хоёрдугаар саналын тухайд: Санхүүгийн зохицуулах хороо нь банк бус санхүүгийн салбарт хяналт хийх, зохицуулахаар хуульчлагдсан. Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны тухай хуулийн дагуу банк бус санхүүгийн байгууллага нь гадаад валютаар зээл олгох үйл ажиллагааг Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлдэг.

Хэдийгээр ББСБ-ын асуудал нь Санхүүгийн зохицуулах хороонд хамаатай хэдий ч үүнтэй холбоотой анхаарал хандуулах хэд хэдэн асуудал байгаа талаар саналаа хуваалцъя. Нэг талдаа банк бус санхүүгийн байгууллагууд харьцангуй хямд хүүтэй эсвэл хувь нийлүүлсэн хөрөнгийн гадаад валютын эх үүсвэртэй байж болно. Ялангуяа, дотоод хуримтлал багатай манай орны хувьд гадаад санхүүжилт нь дотоодын хөрөнгө оруулалтад туйлын чухал байна. Иймд ханшийн эрсдэлийг хеджинг хийх, төгрөг-гадаад валют хоорондын урт хугацааны своп хэлцэл хийх санхүүгийн бүтээгдэхүүнийг зах зээлд хөгжүүлэх, мөн санхүүгийн боловсролоор дамжуулан ханшийн эрсдлийг олон нийтэд ойлгуулах нь илүү үр дүнтэй гэж үзэж байна.



Гэхдээ дотоодын санхүүгийн байгууллагууд болон ААН-ийн хооронд хеджингийн хэлцэл хийгдэхгүй өдийг хүрсэн бөгөөд гадны санхүүгийн байгууллагууд дотоод зах зээлд орж ирэх тохиолдолд энэ төрлийн хэрэгсэл хөгжих суурь бүрдэнэ. Нөгөө талаас санхүүгийн байгууллага нь эрсдэлийг удирдах мэргэжлийн байгууллага тул өөрийн харилцагчдадаа мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлж, санхүүгийн боловсролыг дээшлүүлэх чиглэлд нь шаардлага тавих нь бодит байдалд илүү үр дүнтэй юм. Зээлдэгч зээл авах үедээ ямар эрсдэлүүд хүлээгдэж байгаад үндэслэн төгрөгөөр эсвэл гадаад валютын зээл авах сонголтоо гэрээ байгуулахын өмнө шийдэх нөхцөлийг бүрдүүлэхэд илүүтэй анхаарах учиртай.

Иймд шууд хөрөнгийн хяналт хэлбэрийн арга хэмжээ авахаас илүүтэй зээлдэгчдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, санхүүгийн байгууллагууд мэргэжлийн зөвлөгөө өгөх, зах зээлийн арга хэрэгсэлд суурилсан своп, форвард, фьючерс хэлцлийн бүтээгдэхүүн бий болгох зэрэг арга хэмжээнд түлхүү анхаарах нь чухал байна. Үүний зэрэгцээ зах зээлийн механизмд суурилсан арга хэрэгсэлд банкуудын хувьд валютын заавал байлгах нөөцийн хувийг төгрөгийнхөөс өндрөөр тогтоох, банк болон банк бус санхүүгийн байгууллагыг аль алины хувьд валютын зээлийн эрсдэлийн жинг төгрөгийн зээлийн эрсдэлийн жингээс өндрөөр тогтоох, валютаар олгох зээлийн хэмжээнд банкны баланс, зээлдэгчийн чадавхад тохируулан хязгаар тогтоох гэх мэт макро зохистой бодлогын хэрэгслүүдийг ашиглах боломжтой юм.

3. *“Төрийн алдаатай бодлогын хор хохирлыг иргэд, аж ахуй эрхлэгчдээр үүрүүлэх явдлыг таслан зогсоож, гадаад валютын зээлтэй байгаа нийт иргэд, аж ахуй эрхлэгчдийн зээлийг төгрөг рүү шилжүүлэх”.*

Зарчмын хувьд санал нэг байна. Энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга механизмаа тантай хуваалцъя. Монголбанк ханшийн эрсдэлийг бууруулахын тулд гадаад валютын орлогогүй иргэн, ААН-д валютын зээл олгох үйл ажиллагааг сааруулж, бууруулахад чиглэсэн бодлогын арга хэмжээг авахаар судалж байгаа бөгөөд ирэх оноос хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Монгол улс шиг уул уурхайгаас хэт хамааралтай, эдийн засгаас бүтцээс шалтгаалан гадаад секторын эмзэг байдал өндөртэй орны хувьд экспорт, импортын бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнэ, гадаадын шууд хөрөнгө оруулалт, манай экспортын эрэлт зэрэг нь валютын ханшийн хэлбэлзлийн дийлэнх хэсгийг бий болгодог. Эдгээр хүчин зүйлс валютын ханшийг сулруулах чиглэлд удаан хугацаанд өөрчлөгдсөн бол ханш сулрахаас өөр сонголт манайх шиг гадаад валютын нөөц багатай оронд байхгүй. Иймд валютын ханшийн сулралтыг төрийн бодлогын алдаанаас болсон уу эсвэл гадаад хүчин зүйлсээс болсон уу гэдгийг яг таг тодорхойлох нь эдийн засгийн шинжлэх ухааны хувьд боломжгүй байна. Мөн уул уурхайн шокын эсрэг бодлогын арга хэмжээний нөлөө маш сул үр нөлөөтэй байдаг нь зөвхөн манай улсын хувьд биш бусад уул уурхайгаас хамааралтай улсын хувьд түгээмэл ажиглагддаг. Иймд гадаад валютын ханшийн эрсдэлийг бага байлгахын тулд; нэгд, макро бодлогын алдаа гаргахгүй байх, мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлэх; хоёрт, гадаад валютын зээлээр дамжин ханшийн эрсдэл хуримтлагдахгүй байхаас сэргийлэх; гуравт, гадаад валютын нөөцийг бүрдүүлэх явдал болоод байна. Мөн урт хугацааны бодлогын зорилгын хувьд эдийн засгийн төрөлжилтийг хийх, импортыг орлох, экспортын салбарыг яаралтай хөгжүүлэх шаардлагатай байна.

Иргэд, аж ахуйн нэгж байгууллагын гадаад валютаар авсан зээлийн дүн 2017 оны 10 дугаар сарын байдлаар 1.1 тэрбум ам.доллар байгаа нь нийт зээлийн 20,8 хувийг эзэлж байна. Энэ бүх зээлийг төгрөгт хөрвүүлэх арга хэмжээг төрөөс авч хэрэгжүүлэх тохиолдолд ямар ханшаар хөрвүүлэх вэ гэсэн асуудал гарна.

Харин одоогийн зах зээлийн ханшаар бус зээлдэгчид хөнгөлөлт үзүүлсэн ханшаар шилжүүлэх тохиолдолд холбогдох зардлыг төрд үүрүүлэх шаардлагатай болно. Энэ нь улсын төсөвт дарамт учруулах, мөн банкны салбарын тогтвортой байдлыг алдагдуулах сөрөг үр дагавартай. Улсын өр нэмэгдэж, төсвийн байдал хүнд байгаа үед төсөвт энэ хэлбэрийн ачаалал бий болгох нь бусад нийгмийн зардлуудаа танахад хүргэнэ. Энэ нь өөрөө эдийн засгийн болон улс төрийн үр дагавартай. Харин банкны салбарт энэ зардлыг үүрүүлэх тохиолдолд өөрийн хөрөнгийн дутагдалд орж, дахин хөрөнгөжүүлэхэд эргээд улсын төсөвт дарамт учруулна.

Харин зах зээлийн ханшаар хөрвүүлэх тохиолдолд төрийн оролцоогүйгээр банк, зээлдэгчид өөрсдөө шийдээд хөрвүүлэх боломжтой. Энэ үйл явцыг Монголбанк зохистой харьцааны бодлогын хэрэгслүүдээр дэмжинэ. Мөн түүнчлэн гадаад валютаар зээл авсан иргэн, хуулийн этгээдийн хувьд банкуудаас санал болгож буй гадаад валютын своп, форвард, опшин зэрэг санхүүгийн хэрэгслүүдээс сонгон авч гадаад валютын эрсдэлээ удирдах боломж нээлттэй.

Монголбанк зээлдэгчдийг гадаад валютын ханшийн эрсдэлээс хамгаалах зорилгоор банкны өөрийн хөрөнгийн зохистой харьцааны үзүүлэлтийн тооцоололд ханшийн эрсдэлтэй буюу гадаад валютын орлогогүй иргэд, аж ахуйн нэгжид олгосон гадаад валютын зээлийн эрсдэлийн жинг 20%-иар нэмэгдүүлж, 120%-иар жигнэж байх зохицуулалтыг “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д тусган хэрэгжүүлж байна. Энэ нь зээлийн долларжилтгыг бууруулдаг сонгодог аргуудын нэг юм. Зээлийн долларжилтыг зах зээлд суурилсан арга хэрэгсэл ашиглан бууруулах үүднээс энэхүү эрсдэлийн жинг нэмэгдүүлэх, макро зохистой бодлогын бусад арга хэрэгслүүдийг шат дараатай, иж бүрнээр нь авахаар ажиллаж байна. Эдгээр бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхийг Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл хэлэлцэж, шийдвэрлэх болно. Эдгээр арга хэмжээ нь валютын хадгаламжийг бууруулах, валютын зээлийн хүүг нэмэгдүүлэх, банкууд төгрөгийн зээл олгохыг илүүд үзэх замаар зээлийн долларжилтыг бууруулах нөхцөлийг бүрдүүлдэг.

4. *“Иргэд аж ахуйн нэгж онцгойлон гадаад валютын зээл хүсээгүй бол арилжааны банкуудын зүгээс гадаад валютын зээлийг тулган олгодог явдлыг таслан зогсоох”.*

Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2-т заасны дагуу зээлдүүлэгч нь зээлдэгчтэй зээлийн хүү, хугацаа болон бусад нөхцөлийн талаар харилцан тохиролцсоны үндсэн дээр зээлийн гэрээ байгуулж зээлийн данс нээх, зээл олгох үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлж, зээлийн хэлцэлд орох үед харилцан тэгш эрхтэй байж, өөрийн санхүүгийн байдалд нийцтэй зээлийн гэрээ байгуулдаг болоход дэмжлэг үзүүлэх нь зорилгоор “Олон нийтийн санхүүгийн суурь боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг Монголбанк олон улсын, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж байна. Иймд Монголбанкны зүгээс иргэдийн санхүүгийн суурь боловсролыг дээшлүүлэх, харилцагчдын эрх ашгийн хамгаалах чиглэлд илүү анхаарч байна. Мөн шаардлагатай тохиолдолд газар дээрх шалгалтыг валютын зээлийн хэрэгжилтэд хийж, гарсан зөрчлийн мөрөөр холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад валютын зээлийг тулган олгох нь хууль зөрчсөн үйл ажиллагаа тул хэрэв ийм тохиолдол байгаа бол Монголбанк, холбогдох хуулийн байгууллагад асуудлыг тавьж шалгуулах бүрэн эрхтэй болно.